



ДУНДГОВЬ АЙМАГ
ДЭЛГЭРЦОГТ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 07 сарын 01 өдөр

Дугаар 4/49

Амьдралтай

Хорио цээрийн дэглэмийг сунгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.12 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 32 дугаар зүйлийн 32.1.9, Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.2.1 дэх заалт, Засгийн газрын 2018 оны 08 дугаар сарын 22-ны өдрийн 266 дугаар тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тус сумын Цахиурт багийн нутаг дэвсгэрт бог малын гоц халдварт өвчний голомт үүссэн тул 2022 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс эхлэн 21 хоногийн хугацаатай хорио цээрийн дэглэм тогтоосугай.
2. Голомтын бүсийн координат, цэгийг 1 дүгээр хавсралтаар тогтоосугай.
3. Хорио цээрийн бүсийн хүн амын хөдөлгөөнд хяналт тавьж хэв журам сахиулж ажиллахыг Хэсгийн цагдаа (Л.Отгонбаатар, Б.Ууганбаатар) нарт үүрэгжүүлсүгэй.
4. Хорио цээрийн бүсэд хийгдэх халдваргүйтгэл, малын эрүүл мэндийн үзлэгийг чанартай зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасаг (Д.Наранцэцэг), мал эмнэлгийн үйлчилгээний нэгжийн малын эмч (М.Даваацэрэн) нарт үүрэг болгосугай.
5. Хорио цээрийн бүсэд пост гаргаж малын хөдөлгөөнд хяналт тавьж ажиллахыг Багийн Засаг дарга (Г.Сосорбурам)-д даалгасугай.
6. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд Гамшгаас хамгаалах бие бүрэлдэхүүнийг үүрэгжүүлж ажиллахыг Шуурхай штабын дарга (С.Нарантунгалаг)-т үүрэг болгосугай.

ДАРГА  М.БАЯРСҮХ

4880030756